



Trygghetsfonden TSL, www.tsl.se

Та ажлаас халагдсан бол бид туслана!

Хэрэв та ажил дутагдлаас болж ажлаас халагдсан бол Trygghetsfonden TSL-ээр дамжжигжуулан шинэ ажил олохдоо туслалцаа авах боломжтой. Бид LO болон Svenskt Näringsliv байгууллагуудын хамтын тохиролцоон дээр үүссэн үйлчилгээ үзүүлнэ. Тиймд таны хувьд бүрэн үнэ төлбөргүй.


Танд өөрийн нөхцөл байдалдаа тулгуурлан шинэ ажилд орох, компани байгуулах эсвэл магадгүй суралцаж эхлэхэд тань дэмжлэг үзүүлэх Шведийн шилдэг ажлын дасгалжуулагчдын нэгийг бид танд санал болгоно. Ажлын дасгалжуулагч жишээ нь та өөрөө ч бодоогүй байсан ажлыг олоход тань туслах, эсвэл боловсрол, ажил, мэргэжлийн намтар хэрхэн бичихийг мэднэ. Та Даатгалын касс, Хөдөлмөр зүүчлалын албатай холбоо барихдаа дэмжлэг авах боломжтой. Та мөн тодорхой ажилд орохын тулд богино хугацааны сургалтанд хамрагдах боломжтой байж болно. Хэрэв та 40 нас хүрсэн бол ажлаас халагдсаны тэтгэмж гэж нэрлэгддэг санхүүгийн нөхөн олговор авах боломжтой.

Таны хэрэгцээ биднийг удирдан чиглүүлнэ. Trygghetsfonden TSL-ийн зөвлөх тантай холбоо барьж, дэмжлэг чухам танд ямар ач холбогдолтой байх талаар мэдээлэл өгнө.

Дараагийн хуудсанд тантай холбогдохын өмнө унших ёстой мэдээллийг агуулсан болно.

Сайн холбоосууд


Бидний юу хийдэг тухай богино кино



www.tsl.se дээрх нэмэлт мэдээлэл



Facebook



LinkedIn



Бид хэрхэн ажиллах вэ

1. Trygghetsfonden TSL тантай холбоо барьж, таны нөхцөл байдлын тухай мөн та ямар дэмжлэг авч болох талаар ярилцана
2. Дэмжлэг хүлээн авахаар болвол та өөрийн ажлын дасгалжуулагчтай болно
3. Ажлын дасгалжуулагч шинэ ажилд орох, сурах эсвэл хувийн бизнес эхлүүлэхэд тань таныг дэмжинэ
4. Танд шаардлагатай бол богино хугацааны сургалтанд хамрагдах боломж олгогдоно
5. Та 40-өөс дээш настай бол ажлаас халагдсаны тэтгэмж авах боломжтой (AGB)

Дэмжлэг авах болзол

- байнгын ажлын байр
- хамтын гэрээнд нэгдсэн нэг эсвэл хэд хэдэн компанид дор хаяж 12 сар тасралтгүй ажилласан
- долоо хоногт дор хаяж 16 цаг ажилласан
- ажил дутагдлаас болж ажлаас халагдсан
- 65 нас хүрээгүй

Ажлаас халагдсаны тэтгэмж авах болзол

- сүүлийн таван жилд дор хаяж 50 сар ажилласан
- ажлаас халагдахын даатгал хийсэн нэг эсвэл хэд хэдэн компанид ажилласан
- ажил дутагдлаас болж ажлаас халагдсан
- хамгийн сүүлийн ажлын өдөр гэхэд 40 нас хүрсэн байсан

Ажлаас халагдсаны тэтгэмж 37 885 кроноос 55 100 кроны хооронд байна. Энэ хэмжээ таны наснаас хамаарна. Та өөрөө өргөдөл гаргах үүрэгтэй ба, ажлын дасгалжуулагч өргөдөл гаргахад тань туслах боломжтой. Өргөдөл явуулахын өмнө ажил олгогч тань өргөдөлд гарын үсэг зурах ёстой. Дэлгэрэнгүй мэдээлэл болон өргөдөл энд бий: <http://www.afaforsakring.se/avgangsbidrag>.

